



ХЭНТИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 09 сарын 25 өдөр

Дугаар A/28

Өмнөдэлгэр сум

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үнэлгээ зохиох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дах заалт, Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/80 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны А/80 дугаар тушаалаар баталсан “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналт үнэлгээний аргачлал”-ын дагуу сургуулийн өөрийн үнэлгээг 2025 оны 10 дугаар сарын 06-ны дотор хийхийг сургуулийн “Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд хяналт тавих орон тооны бус зөвлөл”-д даалгасугай.

2.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өөрийн үнэлгээг хийж үр дүн, дүгнэлт саналыг танилцуулах, аймгийн Боловсролын газарт хүргүүлэх ажлыг 2025 оны 10 дугаар сарын 10-ны дотор зохион байгуулахыг “Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд хяналт тавих орон тооны бус зөвлөл”-ийн дарга Ч.Хишигтогтоход үүрэг болгосугай.

3.Өөрийн үнэлгээний үр дүнг сайжруулах, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний жилийн ажлын төлөвлөгөөг сургуулийн эмч, ахлах тогооч, няравтай хамтран боловсруулж батлуулах, мөрдөн ажиллахыг “Хоол үйлдвэрлэл үйлчилгээнд хяналт тавих орон тооны бус зөвлөл”-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ж.СУГАРРАГЧАА

